БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН

# МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

20 19 оны 12 дугаар сарын 27 өдөр

Дугаар 2297/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: .........................

| | |
|---|---|
| **Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:** | Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 26-р хороо "147-р цэцэрлэгийн барилгын засвар"-ын ажлын зураг төсөл, төсөв<br>**Шифр: ТАО-20/2019** |
| **Хүчин чадал:** | **Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 53.16 м x 50.4 м хэмжээтэй, А, Б, В, Г, Д блок<br>**Давхрын тоо:** ± 0.00 түвшнээс доош 1 давхар зоорьтой, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар<br>**Барилгын ажлын талбай:** S= 5310.9 $м^2$ |
| **Захиалагч:** | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Гадаадын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:** | "Түмэн амгалан ордон" ХХК |
| **Регистрийн дугаар:** | РД: 5694442 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2022.04.11 |
| **Ажлын төрөл:** | 1.1.1, 1.1.2, 1.2.2, 1.2.3, 1.2.4, 1.2.5, 1.2.6,1.3.1, 1.3.2 заалтын дагуу |
| **Зураг төсөл боловсруулах үндэслэл:** | |
| Төсөв боловсруулах үндэслэл: | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн захирлын 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдөр батлсан 02/19 дугаартай засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгавар |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан: | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн захирал, "Түмэн амгалан ордон" ХХК-ийн захирал нарын хороонд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 83338974 дугаартай зураг төслийн ажил гүйцэтгэх гэрээ |

| **Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:** | | |
|---|---|---|
| Зураг төслийн иж бүрдэл: | Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Магадлал хийсэн экспертийн нэр: |
| Барилга архитектур: | "Түмэн амгалан ордон" ХХК | Ч.Дагшигдорж |
| Халаалт, агаар сэлгэлт: | "Түмэн амгалан ордон" ХХК | Д.Гантулга |

| | | |
|---|---|---|
| Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж: | "Элста" ХХК | Б.Ванчигмаа |
| Төсөвт өртөг: | "Түмэн амгалан ордон" ХХК | Ө.Энхтогтох |
| **Нэгтгэсэн дүгнэлт:** /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/ | | |
| **Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;** | **Барилга байгууламжийн техникийн шийдэл:**<br>Барилга нь тэнхлэгээрээ 53.16 м x 50.4 м хэмжээтэй, А, Б, В, Г, Д блок, ± 0.00 түвшнээс доош 1 давхар зоорьтой, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар барилга байна.<br>**Барилгын засвар:**<br>Барилгын дулаан алдагдлыг бууруулах зорилгоор суурь, дээвэр, гадна хана, саравч 50 мм, 100 мм, 150 мм-ийн зузаантай 20-22 кг/м$^3$ нягттай хөөсөнцөр хавтангаар дулаалах, хаалга, цонх солих, гадна довжоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам хийх төлөвлөсөн байна.<br>**Агаар сэлгэлт:**<br>Цэцэрлэгийн ангиудын дотор агаарын чанарыг сайжруулах зорилгоор ангиудад механик агаар сэлгэлтийн систем төлөвлөсөн бөгөөд энэ нь эрчим хүчний хэмнэлттэй, автомат удирдлагатай, $CO_2$ мэдрэгчтэй, нарийн ширхэгт тоосонцор шүүх HEPA H13, бүдүүн ширхэгт тоосонцор шүүх G3 шүүлтүүртэй, дулаан солилцуууртай, агаар халаагчтай, гадна агаарын хэм -15$^0$ С-ээс дээш үед усан агаар халаагч ажиллахаар удирдлагад тохируулах мөн $CO_2$ мэдрэгчтэй сэнсний хурдыг 1, 3, 5 дээр тохируулан автоматаар мэдэрч ажиллахаар удирдлагад тохируулга хийгдсэн. Бүлгийн өрөөний систем 7:30-13:00, 15:00-18:00, унтлагын өрөөний систем 13:00-15:00 цагуудад ээлжлэн ажиллахаар тохируулга хийгдсэн байна.<br>**Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:**<br>Хэрэглэгчид цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны II зэрэгт хамаарна. Одоо байгаа ерөнхий самбарт ВА88-32-3Р-125А автомат суурилуулан уг автоматаас ВВГ 5x16 мм$^2$ хөндлөн огтлолтой зэс голтой кабель татаж төлөвлөж буй ХС-1 самбарыг тэжээхээр төлөвлөсөн байна. Шинээр суурилуулах ГС-1, ГС-4 самбараас ангиудад тавигдах сэнснүүдийг тэжээхээр төлөвлөсөн байна.<br>Газардуулга, аянга хамгаалалтыг төлөвлөсөн байна. Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байх шаардлагатай. Сүлжээний хүчдэл 380/220В байна.<br>**Үндсэн үзүүлэлт:**<br>Оролт-1: $P_{т1}$= 25.9 кВт, $P_{c1}$= 32.7 кВт | |
| **Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх;** | **Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:**<br>Экспертүүдийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна. | |

| Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | **Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал:** 147-р цэцэрлэгийн барилгын засварын ажил хийснээр хүүхдүүд ая тухтай цэвэр орчинд сурч хүмүүжих таатай нөхцөл бүрдэнэ. |
|---|---|

**Төсөвт өртгийн нэгдсэн товчоо**

| № | Тодорхойлолт | Төсөвт өртөг /төг/ | Хүчин чадал | Нэгж өртөг /төг/ |
|---|---|---|---|---|
| **1** | **Барилгын дулаан техникийн засварын ажил:** | | | |
| 1.1 | Барилгын засвар: Барилгын суурь, дээвэр, гадна хана, саравч50 мм, 100 мм, 150 мм-ийн зузаантай 20-22 кг/м3 нягттай хөөсөнцөр хавтангаар дулаалах, гадна довжоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам хийх | 568,015,667.0 | 5,310.9 | 106,952.8 |
| | **Хэсгийн дүн:** | **568,015,667.0** | **5,310.9** | **106,952.8** |
| **2** | **Агаар сэлгэлтийн ажил:** | | | |
| 2.1 | Хаалга, цонх: 23.1 м2 хаалга солих, 355.7 м2 цонх солих, 111.3 м2 цонхны чулуун тавцан суулгах, хаалга, цонхны амалгааны засвар хийх | 151,779,258 | 5,310.9 | 28,578.8 |
| 2.2 | Агаар сэлгэлт: Агаар сэлгэлтийн системийн иж бүрэн засвар | 242,446,354 | 5,310.9 | 45,650.7 |
| 2.3 | Дулаан хангамж: Ус хангамжийн ган хоолой, ялтсан ус халаагч, эргэлтийн насос, тэжээлийн насос, температур тохируулах автомат хаалт, даралтын зөрүү тохируулах хаалт угсрах | 46,393,222 | 5,310.9 | 8,735.5 |
| 2.4 | Дотор гэрэлтүүлэг хүчит төхөөрөмж: Агаар сэлгэлтийн системийн тоног төхөөрөмжийн тэжээлийн самбар, гэрэлтүүлгийн самбар, тэжээлийн кабелийн угсралт, газардуулгын ажил | 17,095,516 | 5,310.9 | 3,218.9 |
| 2.5 | Дотор заслын засвар: Агааржуулалтын шугам хоолой суурилуулахтай холбогдон хийгдэх хана, таазны засварын ажил | 7,008,027 | 5,310.9 | 1,319.6 |
| | **Хэсгийн дүн:** | **464,722,375.5** | **5,310.9** | **87,503.5** |
| 3 | **Зураг төслийн ажил:** | | | |
| 3.1 | Зураг төслийн үнэ | 14,000,000.0 | | |
| | **Хэсгийн дүн:** | **14,000,000.0** | | |
| | **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | **1,046,738,043** | |

**Төсөв:** Эксперт нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 26-р хороо "147-р цэцэрлэгийн барилгын агаар сэлгэлт"-ийн ажлын төсөвт өртгийг **478 722 376.0** (дөрвөн зуун далан найман сая долоон зуун хорин хоёр мянга гурван зуун далан зургаан) төгрөг, "147-р цэцэрлэгийн барилгын дулаан техникийн засвар"-ын ажлын төсөвт өртгийг **568 015 667.0** (таван зуун жаран найман сая арван таван мянга зургаан зуун жаран долоон) төгрөг, нийт **1 046 738 043.0** (нэг тэрбум дөчин зургаан сая долоон зуун гучин найман мянга дөчин гурван) төгрөгөөр хянасан байна.

**"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".**

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 26-р хороо "147-р цэцэрлэгийн барилгын засвар"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **5** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ — Ц.АМАРСАНАА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Д.САРАНТУЯА